

Жолоочийн даатгалын тухай хууль

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн
ажлын алба



Улаанбаатар хот
2011 оны 10 дугаар сарын 06

Тээврийн хэрэгслийн тоо

● 1990 онд 43,6 мянга*



● 2010 онд 296,8 мянга
/7 дахин их/



* *Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт тээврийн хэрэгслийн тоо*

Статистик мэдээ

- Тээврийн хэрэгсэл жолоодох эрх авсан иргэдийн тоо
 - ➔ 2010 оны байдлаар: **772 563** хүн
 - ➔ Сайн дурын даатгалд хамрагдсан: **70 000** хүн /дундаж/
- Улсын хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоо
 - ➔ 2010 оны байдлаар: **296 800**
 - ➔ Сайн дурын даатгалтай: **60 000** тээврийн хэрэгсэл
- Автотээврийн ослоор нас барагсдын тоо
 - ➔ Жилд дунджаар: **300** хүн
- Автотээврийн улмаас учирсан эдийн хохирол /төгрөгөөр/
 - ➔ 2010 онд: **2 033 665,01** мянга

Ерөнхий агуулга

- **Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүрийг жолоочийн хариуцлагын албан журмын заавал даатгалд хамруулна:**
- Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж хариуцлага хүлээх тохиолдол бүр хамрагдана;
- Ингэснээр бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, мөн хохирогчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин бий болно;
- Ослын улмаас учирсан хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр бий болно;

АЖЛЫН ХЭСЭГ

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн ажлын хэсэг:

- УИХ-ын гишүүн Г.Батхүү – ахлагч
 - УИХ-ын гишүүн Я.Батсуурь
 - УИХ-ын гишүүн Н.Батбаяр
 - УИХ-ын гишүүн З.Энхболд
- ➡ Бүлгийн ажлын хэсэг АНУ, ХБНГУ, ОХУ зэрэг орнуудын дээрх харилцааг зохицуулсан судалгаанд дүн шинжилгээ хийж УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн.
- ➡ Цахим хэлбэрээр иргэдийн саналыг авч хуулийн төсөлд тусгасан: [/www.facebook.com](http://www.facebook.com), www.democrats.mn/

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн ажлын хэсэг

Ажлын хэсэг дараахь саналыг тусгав. Үүнд:

- Даатгалын хэлбэр нь жолоочоо бус, тээврийн хэрэгслийн өмчлөгчийг дагасан байх;
- ❖ *Ингэснээр тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий 772.563 хүн бус, 290.000 хүрэхгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч энэхүү даатгалд хамрагдах үүрэг хүлээнэ.*
- ❖ *“С”, “D” ангиллын болон тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч замын хөдөлгөөнд оролцохдоо тээврийн хэрэгсэл өмчлөгч мөн эсэхээс үл хамааран заавал даатгалд хамрагдана.*

Жолоочийн даатгалын сан

Даатгагч нарын нөхөн төлөх зорилгоор хамтарч байгуулах сан

Даатгалын тохиолдлыг үнэн зөв, шуурхай тодорхойлж, даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиглэлээр туслалцаа үзүүлэх алба



“Даатгуулагч” гэж даатгагчтай гэрээ байгуулж замын хөдөлгөөнд оролцох үедээ бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан этгээдийг хэлнэ.

/Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.6/

Хөрөнгийн эх үүсвэр

Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийн эх үүсвэр нь:

- ❖ Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгө,
- ❖ Даатгалын мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого,
- ❖ Даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөр,
- ❖ Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь,
- ❖ Бусад зээл, тусламж, хандивын орлогоос бүрдэнэ.

Даатгалын суурь хураамж

Жилээр:

● “А” ангиллын тээврийн хэрэгсэлд: **12,500** төгрөг;



● “В” ангиллын тээврийн хэрэгсэлд: **33,000** төгрөг;



● “С” ангиллын тээврийн хэрэгсэлд: **42,500** төгрөг;



● “D” ангиллын тээврийн хэрэгсэлд: **53,000** төгрөг;





● “Механизм” ангиллын тээврийн хэрэгсэлд: **12,500** төгрөг;



Нөхөн төлбөрийн хэмжээ

Мэргэшсэн болон “С”, “D” ангиллын жолооч:

- “С”  болон “D”  ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч тээврийн хэрэгслийн өмчлөгч мөн эсэхээс үл хамааран өөрийн хариуцлагаа албан журмаар даатгуулах үүрэгтэй;
- Даатгалын тохиолдол бүрт хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ 10 саяас илүүгүй байна.
- Харин “А”, “В” болон “Механизм” ангиллын тээврийн хэрэгслийн хувьд нөхөн олговрын дээд хэмжээ 5 сая байхаар тусгасан. */Нэмэлт даатгалыг сайн дурын даатгалын журмаар зохицуулах боломжтой/*

Жолоочийн хариуцлага

- ❖ 2010 оны байдлаар нийт **8.809** зам тээврийн осол бүртгэгдсэнээс **82,2%** нь жолоочийн буруугаас үүдэлтэй байв.

Хохирогчид олгох нөхөн төлбөр:

- ❖ **80** хүртэлх хувийг хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлыг барагдуулах зорилгоор;
- ❖ **20** хүртэлх хувийг хохирогчийн эд хөрөнгөд учруулсан хохирлыг барагдуулах зорилгоор олгохоор тусгасан байна.



Даатгалын итгэлцүүр

Дараахь итгэлцүүрээр даатгалын суурь хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцно:

- *Тээврийн хэрэгсэл ашиглах газар нутгийн байршил;*
- *Даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөр;*
- *Даатгуулагчийн нас, жолоодох туршлага;*
- *Даатгалын гэрээний хугацаа;*
- *Тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тоо;*
- *Тээврийн хэрэгслийн даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал;*
- *Тээврийн хэрэгслийн зориулалт;*
- *Чиргүүлтэй эсэх;*

Жишээ:



Мөнгөгүй гэх шалтгаанаар хохирлыг барагдуулдаггүй гажуудлыг арилгана.

- Жолоочийн буруугаас үүдэлтэй хохирлыг жолооч барагдуулах боломжгүй бол даатгалын сангаас төвлөрүүлж, учирсан хохирлыг /5-10 сая ₮ хүртэлх хэмжээнд/ барагдуулна.
- Улмаар хохирогчийн эрх ашгийг хамгаалах, хохирлыг заавал нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бий болох давуу талтай.

Дагаж мөрдөх огноо

- “Жолоочийн даатгалын тухай” хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгохтой холбоотой энэ хуулийн 18 дугаар зүйлийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- Даатгалд хамрагдах хугацаа 2012 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.



**Улсын Их Хурал дахь
Ардчилсан намын бүлэг**

**АНХААРЛАА ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**



Бэлтгэсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Б.Ганхөлөг